

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 05 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 05 дугаар сарын 26

Улаанбаатар хот

ДД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээ гүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэ х арга зам	Оноо
Үүрэг, даалгавар-НЭГ: Дүүргийн төсвийн орлогын бүрдүүлэлт, нийслэлд төвлөрүүлэх орлогын тасалдлыг нөхөж, төсвийн тухай хуулийн дагуу орлогын гүйцэтгэлийг хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах.				
1.	Дүүргийн 2022 оны төсвийн орлого 158 790.6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар ессөн дүнгээр 39.2 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлж орлогын төлөвлөгөө 85 хувийн биелэлттэй байна. Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу эхний 4 сарын байдлаар нийт 16.2 тэрбум төгрөгийг шилжүүлэн 100 хувь биелүүлж ажилласан. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган биелүүлж, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Татварын хэлтэстэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг 29 томоохон зах худалдааны төвүүдийн 3669 бизнес эрхлэгчдийг хамруулсан "Хариуцлагатай бизнес эрхлэгч-30" арга хэмжээг зохион байгуулан ажилласан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
Үүрэг, даалгавар ХОЁР: Нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн зам, талбайд хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт шаардлагыг хангасан хоол, хүнсний худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад үйл ажиллагаагаа чөлөөтэй эрхлэх боломж олгон, бүх талаар нь дэмжлэг үзүүлж ажиллах.				
2.	Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Амралтын өдрийн худалдаа зохион байгуулах тухай" А/496 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Тусгаар тогтолын талбайд 2022 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны өдруүдэд Алтжин бөмбөгөр, Юмт бөмбөгөр худалдааны төвүүд болон 25 иргэн, аж ахуйн нэгжүүд 30 нэр төрлийн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаа зохион байгуулан ажиллалаа. Нийслэлийн Засаг даргын Захирамжаар 2022 оныг "Хотын иргэний жил" болгон зарласантай холбогдуулан дүүргийн нутаг дэвсгэрт ил задгай хүнсний болон хүнсний бус худалдаа үйлчилгээ эрхэлж буй 26 иргэдийг хамруулан 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдөр ил задгай хүнсний болон хүнсний бус худалдааны эрүүл ахуйн нөхцөл,	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90

	шандлага, хүнсний агуулгүй байдлыг хангахад анхаарах асуудлуудаар зөвлөн туслах сургалт зохион байгуулж зөвлөмж, гарын авлага хургуулж ажилласан. Мэн “Пи Си Молл ХХК” нь Тусгаар тогтолын талбайд 2022 оны 04 дугээр сарын 20-ны өдрөөс хойш Узэсгэлэн худалдаа зохион байгуулж байна.		
Үүрэг, даалгавар ГУРАВ: Нийслэлд худалдаа, үйлчилгээ явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг орчныхoo 50м хүртэлх талбайн өнгө Узэмжийг сэргээх, цэвэрлэх ажлыг алба Дуурэг, хорооны Засаг дарга нар, Хот нийтийн аж ахуйн байгууллагууд			
3.	Дүүргийн нутаг дэвсгэргт худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад өөрийн өмчтөл эзэмшилт ашиглалтад байгаа газар болон ойр орчны 50м хүртэлх талбайг цэвэрлэх ажлын хүрээнд нийт 3 удаагийн цэвэрлэгээнд зах худалдааны төв, хоол үйлдвэр, худалдаа, үйлчилгээний төвийн 600 гаруй иргэн 45500м ² талбайд чийтэй цэвэрлэгээ, гадна дотор орчны завсар Үйлчилгээг хийж ажилласан. Цэвэрлэгээний тайлан мэдээг 7 хоног бурийн түүрээ гаргат Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанад хургуулэн ажиллаж байна.	= Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	= Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана
4.	Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас СӨХ-ийн дээд зөвлөлтэй хамтран СӨХ-ийн холбоодод дараах чиглэл хургуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. Үндд: - Орон сууцны хороолол дундах зөвшөөрөлгүй, өнгө Узэмжгүй, орц гарч хаасан хашаа хайсыг буулгаж, цэгцэлх. - Түргэн туслаамж болон гол унтраах авто машин хороолол руу чөлөөтэй нэвтрэх нөхцөл боломжийг бурдзуулж ажиллах. - Орчны зруул ахуй, ариун цэвэр, хот цэвэрлэгээ, тээвэрлэлт, тохижилтын ажлуудыг зохион байгуулах, бусад Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах, талаар авах зарим арга хэмжээний тухай “ А/585 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн 2 дугаар хороо Их тойтуу, Бөмбөгөр худалдааны төвийн зүн хойно 2 ширхэг төмөр хашаа /37,6 м ² , 4 дүгээр хорооны Засгийн газрын 12 дугаар байрны баруун урд “Астра” төвийн 2 ширхэг төмөр хашаа, хайс /7,5 м ² , 5 дугаар хорооны Урт цагааны хойно 1 ширхэг төмөр хашаа хайс /6м ² /,yg тус тус буулгаж нийт 51,1 м ² газрыг чөлөөлөн ажилласан. Газрын зөрчил арилгах календарьчилсан төлөвлөгөөний дагуу иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, газар ашиглалтыг сайжруулах, явган хүний зам, талбайн хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/388 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэргт 12 байршилын 168 гарцаашийн газрыг албадан чөлөөлхөхөр төлөвлөгөөний дагуу 1 дүгээр хорооны нутаг дэвсгэргт байрлах 39 дүгээр цэцэрлэгэйн урд, хойно 34 гарцааш, 6 дугаар хорооны 62 дугаар байрны 21 гарцааш, 24 дүгээр байрны зүн талд 12 гарцааш, 24 байрны баруун талд 24 гарцааш, 6 хорооны нутаг дэвсгэргт 23 дугаар байрны 5 гарцааш, 41 дүгээр байрны урд талын 11 гарцааш, 6 дугаар хорооны 49 дүгээр байрны хойд талын 24 гарцааш нийт 131 гарцааш албадан буулгах арга хэмжээг зохион байгуулсан ажиллалаа. Дүүргийн 5 дугаар хорооны 24 дүгээр байрны баруун талын газрын зөрчлийг арилгтан 1100 м ² нийтийн эзэмшилийн талбайг тохижуулах саналыг 2022 оны 05 дугаар сарын 02-	= Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	= Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана

	ны өдөр Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны "Газрын менежмент төлөвлөлтийн хэлтсийн дотоод сүлжээгээр судалгаа, танилцуулгыг хүргүүлэн ажилласан.			
Үүрэг, даалгавар ТАВ: Хороодын Засаг дарга нар нутаг дэвсгэрийнхээ нийтийн эзэмшилийн газар, зам талбайн, орчны эрүүл ахуй, хог хаягдал, ариун цэврийн байдалд хяналт тавих, иргэдийн оролцоог хангах ажлуудаа эрчимжүүлж, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах. /Дүүргийн Засаг дарга нар/				
5.	<p>Нийтийн эзэмшилийн гудамж зам талбайн, далан суваг, гуу, жалга зэрэг байршуудад Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК-ний харьяа иргэдийн бүлгийн 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй түүвэр цэвэрлэгээг 7 хоногт 2-3 удаагийн давтамжтай тогтмол цэвэрлэн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 85 гаруй рейсээр 253,5 тонн хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн байна. Мөн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуй нэгж байгууллагуудад дүүргийн тохижилт, ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтыг сэргээх хог хаягдлыг цэвэрлэж зайлцуулах, ил задгай хог хаягдалгүй байлгах нөхцөлийг бүрдүүлэх, байгууллагын хана, фасад, цонх, хаяг, хаягийн байгууламж, сандал, хогийн сав, үүд, довжоогоо угаах засварлах, гадна талбайгаа усалж чийгшүүлэх зэрэг үүрэг чиглэлийг тогтмол хүргүүлэн хэрэгжилтийг дүүргийн Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс хамтран сар бүр хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Иргэдийг эрүүл аюулгүй, цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ" арга хэмжээг 2022 оны 04 дүгээр 26-ны өдөр дүүргийн 1-20,24 дүгээр хороодын нутаг дэвсгэрт зохион байгуулан, аж ахуй нэгж байгууллага, зах худалдааны төв, иргэдийг хамруулан ажилласан.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
Үүрэг, даалгавар ЗУРГАА: Хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор цахилгааны ил гарсан утас, ухсан нүх, явган хүний замын тэмдэглэгээ, орц гарц, сургууль орчмын хурд сааруулагчийг засаж сайжруулах, стандартад нийцүүлэх, хүүхдийн тоглоомын талбайг засаж сэлбэх, эзэнгүй нохой, мууранд хазуулахаас урьдчилан сэргийлэх ажлууд эрчимжүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах.				
6.	<p>- Дүүргийн нутаг дэвсгэрт хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тасарч шалбарсан цахилгааны ил гарсан утас, ухсан нүхний мэдээллийг тухай бүрт нь, засварлаж сэргээх шаардлагатай явган хүний замын гарцын тэмдэг тэмдэглэгээ, орц гарц, сургууль орчмын авто замын хурд сааруулагчийн мэдээллийг 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг хороодын Засаг дарга нарт 2022 оны 3/1326 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Хүүхэд хамгаалах чиглэлээр орон сууц, барилга байгууламжийн гадна байрлах хүүхдийн тоглоомын талбайн эрүүл ахуйн орчин, аюулгүй байдлыг хангуулах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, траншейны таггүй нүх, ил задгай дулааны шугам хоолой, гэмтэлтэй ил гарсан цахилгааны утас байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах талаар 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр уулзалт зохион байгуулж, 202214015</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100


	<p>дугаартай зөвлөмжийг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 46 сүүц өмчлөгчдийн холбоо (СӨХ)-дуудад хүргүүлэн ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> - Дүүргийн хэмжээнд нийт 63 бичил цэцэрлэг байгаа бөгөөд одоогийн байдлаар нийт урсгал засварын ажлыг дүүргийн “Тохижилт Үйлчилгээ ХХК”-тай хамтран 21 бичил цэцэрлэгийн засвар шинэчлэлтийн ажлыг дуусгаад байна. - Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нохой устгалын ажлыг эрчимжүүлэх зорилгоор 1-24 дүгээр хороодын засаг дарга, хэсгийн ахлагчид үүрэг чиглэлийг хүргүүлэн Их булаг АТҮК-ний дуудлагын утас болох 96220504 тоот утсаар цаг тухай бүр дуудлага хүргүүлэн ажиллаж байна. 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 450 гаруй золбин нохойг устган ажилласан. - Дүүргийн Замын цагдаагийн газар 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 57 дугаар сургууль, 258, 275 дугаар цэцэрлэгүүдэд хяналт шалгалт хийж ажилласан. Хяналт шалгалтын явцад 258 дугаар цэцэрлэг нь MNS 6444:2014 стандартын шаардлага хангаагүй, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, авто замын тэмдэг тэмдэглэгээ байхгүй, хүүхэд зам тээврийн осол хэрэгт өртөж болзошгүй өндөр эрсдэл бүхий байсан. Энэхүү цэцэрлэг нь гэр хорооллын гудамжинд дунд шороон замтай үзэгдэх орчин муутай газарт байрладаг ба Сургууль орчмын бүс 5.25, 5.26 тэмдэг, 1.19 “Хүүхэд” анхааруулах тэмдгийг шинээр байрлуулах саналыг нийслэлийн авто замын хөгжлийн газарт хүргүүлэн ажилласан. Мөн Ерөнхий боловсролын 145, 149,139 дүгээр сургууль нь 2021 онос үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд сургууль орчмын бүс MNS 6444:2014 стандартын шаардлага хангаагүй, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, авто замын тэмдэг тэмдэглэгээ байхгүй хүүхэд зам тээврийн осол хэрэгт өртөж болзошгүй өндөр эрсдэлтэй бөгөөд сургууль орчмын бүс 5.25, 5.26 тэмдэг, 1.19 “Хүүхэд”-дэд анхааруулах тэмдгийг шинээр байрлуулах саналыг тээврийн цагдаагийн албаны зам тээврийн хяналтын хэлтэст хүргүүлэн ажилласан. 			
Үүрэг, даалгавар Долоо: Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтсан байгууллагууд хариуцсан чиг үүргийн ажлаа богино хугацаанд эрчимтэй зохион байгуулж, нэгдсэн арга хэмжээний бэлтгэл ажлаа сайтар хангаж ажиллах.				
7.	Dүүргийн Засаг даргын 2022 оны A/174 дүгээр захирамжаар Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хуралдааныг 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулж, хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулах 24 үйл ажиллагаа бүхий бэлтгэл ажлын төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Ажлын хэсгийн хурлаар дүүргийн 1-19 дүгээр хороодын хөгжлийн бэрхшээлтэй болон бүтэн өнчин зэрэг зорилтот бүлгийн нийт 682 хүүхдэд дүүргийн Засаг даргын гарын бэлгийг гардуулж, 6 дугаар сарын 01-ний өдөр Тусгаар	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70

	тогтнолын талбайд нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.			
Үүрэг, даалгавар НАЙМ: “Улаанбаатар Марафон 2022” олон улсын гүйлтийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтсан байгууллагууд хариуцсан чиг үүргийн ажлаа богино хугацаанд эрчимтэй зохион байгуулж, нэгдсэн арга хэмжээний бэлтгэл ажлаа сайтар хангаж ажиллах.				
8.	“Улаанбаатар марафон 2022” олон улсын гүйлтийн арга хэмжээнд дүүргийн иргэд, төрийн албан хаагчид нийт 759 хүний бүртгэлийг хийснээс баталгаажуулсан иргэдийн тоо 525 буюу 69% нь баталгаажуулалт хийсэн байна. 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр оролцох иргэдийн бүртгэлийг 1000-д хүргэхээр ажиллаж байна. Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, дүүргийн Биеийн тамир, спортын хорооны пэйж хуудсаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийдээр мэдээ мэдээллүүдийг түгээн ажиллаж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
Үүрэг, даалгавар ЕС : “Улаанбаатар Марафон 2022” олон улсын гүйлтэд байгууллага хамт олноо идэвхтэй оролцуулж, олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлуудыг зохион байгуулах. /Нийт байгууллагууд/				
9.	“Улаанбаатар Марафон 2022” олон улсын гүйлтэд дүүргийн иргэд, залуучууд, ажилтан, албан хаагчдыг идэвхтэй оролцуулах зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн “Оролцоог хангаж ажиллах тухай” 3/1235 дугаар албан бичгээр дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албад, дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, хороод, ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн нийт 119 байгууллагад чиглэл хүргүүлэн ажилласан. Мөн 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдөр 08.00 цагаас Урт цагааны талбайд Улаанбаатар марафоны нээлтийг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, үргэлжлүүлэн Сүхбаатарын талбайд зохион байгуулагдах нэгдсэн үйл ажиллагаанд оролцооор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.			70
Үүрэг, даалгавар АРАВ: Иргэд олон нийтийн амгалан тайван байдал, нийгмийн хэв журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сээрэмжлүүлэх, аюулгүй байдлыг ханган, хяналт тавьж ажиллах.				
10.	Иргэд, олон нийтийн амгалан тайван байдал, нийгмийн хэв журам, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сээрэмжлүүлэх, аюулгүй байдлыг ханган, хяналт тавьж ажиллах чиглэлээр “Анзаар”, “Шингэрүүлсэн шатдаг хий”, “Сээрэмжлүүльье”, “Илрүүлэлт”, “Замын хөдөлгөөний цагаан толгой”, “Зөвийг хэвшүүльье”, “Явган орчигчийн аюулгүй байдал-Сургуулилт орчмын бус-Хүүхэд” “Хяналт-2” зэрэг нэгдсэн болон тусгай арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Арга хэмжээний хүрээнд дүүргийн 1-19 дүгээр хороодын нийтийн эргүүл хэсгийн байцаагч, хороон цагдаагийн хамтаар явган эргүүлийн үүрэг гүйцэтгэж иргэдэд Залиах, хулгайлах, халаасны хулгайн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн талаар мэдээлэл хүргэж ажилласан.			100

	<p>Монгол Улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагауд үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ аюулгүй, амгалан тайван орчныг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж буй шалтгаан нөхцөлийг арилгаж, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн 10-19 дүгээр хороонд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэдтэй тус хэлтсийн төлөөлөл болон хорооны Засаг даргын ажлын алба уулзаж, санал хүсэлтийг нь хүлээн авч, "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах түншлэлийн гэрээ"-г байгуулан ажиллаж байна.</p> <p>Үүрэг, даалгавар АРВАН НЭГ: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, албан бичгийг бүх талаас нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэйгээр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгч ажиллах. /Нийт байгууллагауд/</p>		
11.	<p>- 2022 оны 05 дугаар сарын 25-ны байдлаар Засаг даргын Тамгын газарт нийт 451 өргөдөл ирснээс 248 -ийг шийдвэрлэж, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн – 1, шийдвэрлэх шатандаа судлагдаж байгаа 68 өргөдөл хүсэлт байна.</p> <p>Хугацаандаа шийдвэрлэсэн – 376, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн – 6 байна.</p> <p>Өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ иргэнд хариу өгсөн хэлбэрээр нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Иргэний талд шийдвэрлэсэн 238 ✓ Боломжгүй тухай хариу өгсөн 73 ✓ Бусад хариу өгсөн 67, Үүнээс: ✓ Программ мессежээр 101 ✓ Программ мессеж утсаар 235 ✓ Программ мессеж албан бичгээр 46 байна. <p>- Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 10 хоног 6 цаг 12 минут байна.</p> <p>Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлтэйгээр эцэслэн шийдвэрлэх, зөрчлийг бууруулах зорилгоор Тамгын газрын харьяа хэлтэс албадын өргөдөл гомдлын нэгдсэн тоон мэдээ, зөрчлийн тайланг хэлтэс, албан хаагч бүрээр танилцуулан цаашид өргөдөл, гомдлын зөрчлийн тоог бууруулахаар заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.</p> <p>Дүүргийн хэмжээнд ирсэн өргөдөл, гомдлын нэгдсэн тайлангийн зөрчлийн талаар Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, хороо, сургууль, цэцэрлэг зэрэг нийт 105 байгууллагад "Зөрчил арилгаж, ажлын хариуцлагыг сайжруулах тухай" 2022 оны 1/1125 тоот албан бичиг хүргүүлсний дагуу хурлын тэмдэглэлээр сануулах арга хэмжээ авч ажилласан тухай 8 байгууллагаас хариу ирүүлээд байна.</p> <p>- Дүүргийн хэмжээнд ирсэн албан бичгийн нэгдсэн тайланг Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, хороо, сургууль, цэцэрлэгийн удирдлагад "Зөрчил арилгаж, ажлын хариуцлагыг сайжруулах тухай" 2/897, 2/898, 2/899, 2/900, 2/901, 2/902 тоот албан бичиг хүргүүлсний дагуу 2 байгууллага зөрчилтэй 18 албан хаагчид сануулах хуудас өгч, 4 байгууллага хурлын тэмдэглэлээр сануулах арга хэмжээ авч ажилласан тухай хариу ирүүлээд байна.</p>		90

	<p>Дүүргийн хэмжээнд 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 1721 албан бичигт хяналтын ажлыг хийж, 1711 бичгийг батлан, шийдвэрлэлт хангалтгүй 25 албан бичгийн шийдвэрлэлтийг цуцалж, 15 албан хаагчид зөрчил тооцон ажилласан.</p> <p>Баримт боловсруулалт, тоон гарын үсэг ашиглах, шинээр авах, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандарт, нэгдсэн системийн ашиглалт, шийдвэрлэлтийн талаар арга зүйн зааврыг ЗДТГ, харьяа байгууллагын 245 албан хаагчтай тухай бүр ажлын байран дээр болон утсаар заавар зөвлөгөө өгч, шаардлага тавин ажилласан.</p>			
Үүрэг, даалгавар АРВАН ХОЁР: Нийслэлийн нутгийн захирагааны байгууллагууд Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналаа яаралтай Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлэх. /Нийт байгууллагууд/				
12.	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/2093 тоот албан бичгийн дагуу Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөлд оруулах саналыг дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс албад, Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албад болон хороодоос авч нэгтгэн хугацаанд нь хүргүүлэхээр ажиллаж байна.</p>			30
Үүрэг, даалгавар АРВАН ГУРАВ: Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлыг сайтар хангах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар болон бусад мэргэжлийн чиг үүргийн байгууллагууд/				
13.	<p>Дүүргийн Цагдаагийн газар: Үндэсний их баяр наадмын хамгаалалт зохицуулалттай холбогдуулан автомашин, техник хэрэгслийг засвар үйлчилгээ хийж, бүрэн бүтэн байдлыг хангуулан ажиллаж байна. Мөн баяр наадмын хамгаалалт зохицуулалттай холбогдуулан автомашин, техник хэрэгслийг засвар үйлчилгээ хийж, бүрэн бүтэн байдлыг хангуулан ажиллаж байна.</p> <p>Онцгой байдлын хэлтэс: Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлыг хангах чиг үүргийн хүрээнд “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” албан даалгавар, дүүргийн онцгой комиссын даргын 2022 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн бэлтгэл ээлжийн давхардсан тоогоор нийт 185 алба хаагч 2 автомашинтайгаар ногоон бүсийн эргүүлээр үүрэг гүйцэтгэн иргэд олон нийтэд ой хээрийн түймэр болон өнжмөл шар өвсний гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж, ухуулга сурталчилгааг хүргэн, нийт 2144 ширхэг тараах санамж материалыг тараан ажиллалаа. “Ой хээрийн гал түймэртэй тэмцэх автомашин техник тоног төхөөрөмж, багаж зэвсэглэмжид үзлэг шалгалт хийж бэлэн байдалд оруулж ой хээрийн түймрийн үед ашиглагдах гөвүүр 10 ширхэг, тросон шүүр 10 ширхийг шинээр хийж бэлэн болгон ажиллаж байна.</p> <p>Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын нөөц сангаас 8,440,000 төгрөгийг шийдвэрлүүлэн бага оврын цахилгаан үүсгүүр /мотор/ 1, гал</p>			90

	түймэр унтраах үүргэвч 12, хүрз 20 ширхэг 3 төрлийн багаж зэвсэглэмжийг шинээр авч бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллаж байна.		
Үүрэг, даалгавар АРВАН ДӨРӨВ: Хог хаягдлын менежмент болон төлбөр хураамжийн асуудлаар тооцоо судалгаа, цаашид авах арга хэмжээний саналаа боловсруулж танилцуулах. /Захирагийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар, Хот тохижилтын газар/			
14.	Хог хаягдлын төлбөр хураамжийн тооцбо судалгааг эцэслэн гаргаж Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр өргөн барихаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.		50


 ДАРГА
 Н.БАТСҮМБЭРЭЛ
 ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
 П.БАЯНБААТАР
 ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
 ДАРГА
 Н.ХАНГАЙ
 ХЯНАСАН:
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
 ДАРГА
 М.НАВЧАА
 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
 МЭРГЭЖИЛТЭН
 У.МАГНАЙ
 НЭГТГЭСЭН:
 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
 МЭРГЭЖИЛТЭН
 Д.ДОЛГОРМАА